



ӨМНӨГОВЬ АЙМАГ

ОРОН НУТГИЙН МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

Өмнөговь аймгийн
2019 оны 8 ДУГААР сарын мэдээ

Нэг. Удирлага, зохион байгуулалтын хүрээнд

- Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт боловсруулах арга зүйн сургалтад аймгаас байгуулагдсан ажлын хэсгийн гишүүд хамрагдлаа. БНХАУ-ӨМӨЗО-ны Альшаа аймаг, Өмнөговь аймаг хооронд байгуулсан санамж бичгийн хүрээнд Өмнөговь аймгийн баруун 3 сумын тог цахилгааны асуудлаар энэ сарын 22-26-ны өдрүүдэд аймгийн Засаг даргаар ахлуулсан, тамгын газрын албан хаагчид болон бусад нийт 20 гаруй албан хаагчид Альшаа аймгийн Баян хотод ажиллалаа. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 15 албан хаагч ээлжийн амралтаа авсан бөгөөд 9 дүгээр сарын эхээр ажилдаа орохоор хуваарьтай байна. Түүнчлэн энэ сард АНУ-аас Монгол улсад суух онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Майкл С.Клечески аймгийн төв Даланзадгад хотын бүтээн байгуулалттай танилцах болон бусад чиглэлээр албан айлчлал хийлээ.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

- Эрүүл мэндийн чиглэлээр

Эмэгтэйчүүд залуучуудын эрүүл мэндийн дэмжих нэгдсэн хөтөлбөрийн хүрээнд Ханбогд, Гурван тэс сумдын хүн амд явуулын нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ явуулын үзлэг оношилгоог Халдварт өвчин судлалын үндэсний төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмч мэргэжилтгүүд хамтран зохион байгуулж байна. Нийт үзлэгт эрэгтэй 731, эмэгтэй 1375 нийт 2106 хүнд, 6247 удаагийн үзлэг, шинжилгээ хийсэн. Ханбогд, Гурван тэс сумдын Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдээс 36.2%-ийг эмэгтэйчүүд эмчийн үзлэг, БЗДХ-ын шинжилгээ, оношилгоонд хамруулсан байна. Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд ЭМГ, УЗХороотой хамтран "БУМБАРДАЙ" хүүхдийн зуны сувилалын үйл ажиллагааг 2 дахь жилдээ зохион байгуулж байна. Сувилалын үйл ажиллагааг 3 ээлжээр зохион байгуулж зорилгод бүлгийн нийт 45 хүүхдийг хамруулахаар төлөвлөж байна. Сувилалын 1-р ээлжинд ӨНӨ-ОРШИХ ӨЭМТөвд харьяалалтай өсөлт, хоол тэжээлийн дутагдалтай, эмзэг бүлгийн өрх гэр бүлийн 15 хүүхдийг хамруулж эхэлсэн.

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр

Улсын хэмжээнд Залуучуудын хөгжлийг дэмжих сарын аяныг 8 сарын 12-оос 9 сарын 12 хүртэл хугацаанд зохион байгуулдаг бөгөөд Өмнөговь аймгийн хэмжээнд залуучуудын хөгжлийг дэмжих сарын аяныг “Залуусын хүч төсөөллөөс илүү” нэртэйгээр амжилттай зохион байгуулж байна. Сарын аяны хүрээнд нийт 18 ажил, арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөн хэрэгжүүлэн ажиллаж байна. Хөгжлийн ирээдүй Оюунлаг залуучууд хөтөлбөр, “Залуусын хүч төсөөллөөс ч илүү” залуучуудын хөгжлийн сарын аяны хүрээнд Өмнөговь аймгийн Залуу багш нарын чуулга уулзалтыг 8 сарын 19-нд Буянт хотхон хүүхдийн зусланд зохион байгууллаа. Чуулга уулзалтад ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсролын байгууллагын 1-5 жил ажиллаж буй 100 залуу багш нар хамрагдлаа. Хөгжлийн ирээдүй Оюунлаг залуучууд хөтөлбөрийн хүрээнд залуучуудын урлаг, спорт, оюун ухааны их наадмыг 7 сарын 25-27-ны өдрүүдэд Даланзадгад суманд зохион байгууллаа. Наадамд 14 сум, 8 багийн 1300 гаруй тамирчид 13 төрлөөр өрсөлдөж шилдэгүүдээ шалгарууллаа.

- Боловсролын чиглэлээр

2019 оны 08 сарын 15-19-ны өдрүүдэд Багшийн мэргэжил дээшлүүлэх институттай хамтран “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх арга зүй” сургалтыг зохион байгуулж,

сургууль, цэцэрлэгийн багш, удирлага нийт 1076 хүнийг хамруулсан. Улаанбаатар хотоос 29 сургагч багш орон нутагт ирж 19 судлагдахуунаар сургалтыг зохион байгууллаа. Цогтцэций сумын 960 хүүхдийн сургуулийн барилгын гүйцэтгэгчээр “Грийн ресурс констракш” ХХК шалгарч, 6.7 тэрбум төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээг байгууллаа. Цогтцэций сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилгын гүйцэтгэгчээр “Хос борь морь” ХХК шалгарч, 2.2 тэрбум төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээг байгууллаа. Сургууль, цэцэрлэгт тоног төхөөрөмж нийлүүлэх” ажлын гүйцэтгэгчээр “Хос могойн чуулган” ХХК шалгарч, 181.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээг байгуулан, ажлыг хийж гүйцэтгэж байна. Баян-Овоо сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын гүйцэтгэгчээр “Тэлмүүн доной” ХХК шалгарч, ажил гүйцэтгэх гэрээг байгуулан, ажлыг эхлүүлж байна. 2019-2020 оны хичээлийн жил эхлэх гэж байгаатай холбогдуулан сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтан, БСУГ-ын удирдлагуудын хурлыг зохион байгуулж, үүрэг чиглэл өгч ажиллаж байна. Энэ хичээлийн жилд аймгийн хэмжээнд 29 цэцэрлэг, 22 сургууль үйл ажиллагаагаа эхлүүлэх гэж байна. “Орон нутагт дутагдалтай хүний нөөцийг бүрдүүлэх тэтгэлэгт” хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, шинээр 44 оюутныг хамруулан гэрээ байгуулаж, хуучин тэтгэлэгт хамрагдаж байгаа 81 оюутны гэрээний сунгалтыг хийн, сургалтын төлбөрийг хариуцан санхүүжүүлэхээр болоод байна.

Тав. Зам тээвэр, барилга, хот байгуулалтын чиглэлээр

- Авто тээврийн чиглэлээр:

Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэний нөхөн олговрыг Даланзадгад зорчигч тээвэр ОНӨААТҮГ-д 7 дугаар сарын захирамжийг гарган СТСХ-г хүргүүлсэн. Постын төлбөр хураасан орлого 100 хувь замын санд төвлөрүүлсэн ба 2019 оны төсөвт постын ажилчдын цалин болон ашиглалтын зардлыг санхүүжүүлэх зардал тусгагдаагүйгээс журмын дагуу постын хэвийн үйл ажиллагааг хангах зардалд замын сангаас зарцуулж чадахгүй байгаа. Иймд орлогын 50 хувийг зарцуулж, 50 хувийг замын санд төвлөрүүлэхээр төлөвлөн, -Баяндалай чиглэлийн авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийн орлогоос авто замын постын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах зардлыг санхүүжүүлж, орлогын 50 /тавь/ хувийг замын санд төвлөрүүлэхийг “Даланзадгад зорчигч тээвэр” ОНӨААТҮГ азарт зөвшөөрлийг олгосон захирамж гарган хүргүүлсэн.

- Барилга, нийтийн аж ахуйн чиглэлээр:

Барилгын тухай хууль, холбогдох журмын дагуу улсын комисс ажиллуулах хүсэлтийг хүлээн авч 9 аж ахуйн нэгж байгууллага, иргэний хүсэлтийн дагуу улсын комисс ажиллах захирамжийг гарган ГХБХБГ-т хүргүүлэв. Ажил гүйцэтгэх гэрээ байгуулах чиглэлээр Ханбогд сумын Хайрхан багийн гадна шугам сүлжээний ажлыг “Оргил таур” ХХК, “Номгон сумын төвийн хатуу хучилттай авто замыг барих” ажлыг “Беринг” ХХК-тай тус тус гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн байна. Мөн Дардан говь ХХК, Даянбайгаль ХХК, Хүслэнт бүтээмж ХХК-иудын хүсэлтийн дагуу гэрээ сунгалт хийж хяналт тавин ажиллаж байна. Өмнөговь аймгийн Ханхонгор сум, Цогт-Овоо сумдын нутаг дэвсгэрээр дайран өнгөрч буй том оврын ачаа тээврийн автомашины явах шороон замын чиглэлийг сумын Засаг даргаас ирүүлсэн саналын дагуу тогтоож хүргүүлсэн. Барилга, хот байгуулалтын сайд, аймгийн Засаг даргын хооронд засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг албан бичгээр хүргүүлсэн. Мөн “Хот төлөвлөлтийн шаардлага хангахгүй барилгажсан хэсгийг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам”-ын төслийн 7 дугаар бүлэг, Төсөл хэрэгжүүлж дуусгах хэсгийн 7.2. дахь заалтад “Төслийг хэрэгжүүлж дуусах хүртэлх хугацаанд сонгосон талбай дахь газар төрийн мэдэлд байна” гэж заасан нь төслийг хэрэгжүүлэх хугацаанд бий болох эрсдэлийг төсөл хэрэгжүүлэгч компани хариуцахын зэрэгцээ орон сууцны борлуулалттай холбоотойгоор эргэлтийн хөрөнгийн дутагдалд орох, төслийн талбай дахь газрыг барьцаалан арилжааны банкнаас зээл авах талаар хүсэлтийг төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс ирүүлдэг. Иймд төслийн талбай дахь газрыг оролцогч талуудын эрх ашгийг хөндөхгүй байх талаар журмаар зохицуулах практик шаардлага тулгарч байгаа талаар Барилга хот байгуулалтын яаманд журмын төсөлд санал хүргүүлсэн.

Зургаа. Төсөв, санхүүгийн чиглэлээр

Улс болон орон нутгийн төсвийн байгууллагуудын Төсвийн гүйцэтгэлийн 7-р сарын мэдээг хүлээн авч орлого, зарлага эдийн засгийн ангилал тус бүрээр Фрибаланс программ дахь төсвийн

гүйцэтгэлтэй тулган шалгаж, Сангийн яамны Төрийн сангийн газарт мэдээг татууллаа. Нийт 43 төсөвт байгууллагуудын 2019 оны 7 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч, хянан баталгаажуулсан. Төсвийн орлогын 7-р сарын мэдээг Аймгийн Татварын газартай тооцоо нийлж, баталгаажуулан хүлээн авлаа. Орон нутгийн байгууллагуудын 7 сарын байдлаарх өр авлагын мэдээг авч, нэгтгэн Сангийн яаманд илгээлээ. Сумдын санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвийн байгууллагуудын 8-р сарын санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олголоо. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 8-р сарын санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олголоо. Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын баталгаажсан ажлын санхүүжилтийг олгож байна. Аймгийн төрийн сангийн харьяа 43 төсвийн байгууллагын үндсэн данс болон, нэмэлт санхүүжилтийн дансны төлбөр тооцоог өдөр тутамд төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу, эдийн засгийн ангилалын дагуу хянаж, хийж гүйцэтгэн, баталгаажуулж ажиллалаа. Өмнөговь аймгийн нийт 15 сумаас ирүүлсэн Фрийбаланс программд бэлтгэн нийлүүлэгчийн данс нэмэх, бэлтгэн нийлүүлэгчийн мэдээллийг засварлах, Санхүү албаны дарга нарын гүйлгээ баталгаажуулаагүй орхигдуулсан эсэх, төсвийн байгууллагын орлого хаах журналын бичилт хийх, сумдын орлого хаасан эсэхэд хяналт тавин ажиллалаа. Төрийн сангийн фрийбаланс программд бүртгэлгүй хувь хүн болон аж ахуй нэгж байгууллагуудын Санхүү, төрийн сангийн хэлтэст ирүүлсэн хүсэлтийн дагуу регистрийн дугаар, нэр, арилжааны банкны дансны дугаарыг төрийн сангийн фрийбаланс программд шинээр бүртгэсэн. Нэмэлт санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлтийг сум, байгууллагуудаас аван нээж ажиллалаа. Төсвийн тухай хуулийн цаглабарын дагуу орон нутгийн 2020 оны төсвийн төсөл, 2021-2022 оны төсвийн төсөөллийг 15 сумын болон төвийн байгууллагуудаас зарлагын төсвийн төслийг, Татварын хэлтсээс орлогын төсвийн төслийг авч нэгтгэн орон нутгийн 2020 оны суурь орлогыг 138,6 тэрбум төгрөгөөр, суурь зарлагыг 57,7 тэрбум төгрөгөөр Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газарт 2019 оны 08 дугаар сарын 09-19-ны хооронд хүргүүлж ажиллалаа. 2019 оны хагас жилийн тайланг хүлээн авч нэгтгэн Сангийн яаманд 2019 оны 08 сарын 09-19-ны хооронд тушаасан.

Долоо. Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр

Аймгийн засаг даргын албан даалгаврын эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн. Засгийн газрын шийдвэр 5, аймгийн Засаг даргын 161 захирамж, бүгд 166 шийдвэрийг хүлээн авч бүртгэн хяналтад авах, удирдлагад танилцуулан хариуцсан албан тушаалтанд хүргэх ажлыг хийлээ. Сум хөгжүүлэх сангийн тайланд ХШҮ хийж тайлан дүгнэлтээ бичиж байна. Орон нутгийн хөгжлийн сангийн тайланд ХШҮ-г хийж тайдан, дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлэхэд бэлэн болсон.

Найм. Батлан хамгаалах чиглэлээр

“Цайдам“ дохионы хадгалалт хамгаалалтыг 02-ны өдөр Цэргийн штабын дарга хурандаа Ж.Амаржаргал шалгаж тэмдэглэл хөтөлсөн. Дохионы хадгалалт хамгаалалт хэвийн байна. Цэргийн штабыг байлдааны бэлэн байлдааны бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлэн Зэвсэгт хүчний анги салбаруудыг бие бүрэлдэхүүн, зэвсэг техникээр нөхөн хангах төлөвлөгөөний дагуу Зэвсэгт хүчний 167 дугаар анги, Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 252, 104 дүгээр тусгай ротууд, Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн 148 дугаар тусгай салбаруудтай тодотголыг явуулж, тодолголын актыг ЗХЖШ-т хүргүүлсэн. Цэргийн бэлтгэл үүрэгтний шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж, бүртгэл тооцоог хөтлөн, цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хааж буй иргэдийн мөнгөн төлбөрийн барагдуулалтад хяналт тавих, бүртгэлийг хөтлөх, журмын хэрэгжилтийг ханган ажилласан. Бусад газраас ирсэн болон Цэргийн штабаас явуулсан бичиг баримтыг бүртгэх, иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг хүлээн авах ажлуудыг тухай бүрт нь шийдвэрлэн ажилласан. Батлан хамгаалах их сургуулийн Ахлагчийн сургуульд элсэхээр бүртгүүлсэн элсэгчдээс ур чадварын буюу бие бялдрын шалгалт авч элсэлтийн шалгалтын комисст өгөв. Халх голын ялалтын түүхт 80 жилийн ойг угтан зохион байгуулсан бүтээлч ажлын тайланг сумдаас авч, нэгдсэн тайланг гаргаж, бүтээлч аяныг дүгнэн, байгуулага, хувь хүнийг шалгаруулан, шагнуулах болон Халх голын ялалтын 80 жилийн ойн арга хэмжээнд оролцох алба хаагчдын нэрсийг ирүүлэх албан бичгийг байгууллагуудад хүргүүлсэн. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд өдөр бүр аймгийн хэмжээнд болж буй үйл явдлын талаар мэдээ өгч ажиллав. Аймгийн

баяр наадмыг зохион байгуулах хурдан морины салбар комисс, “Торгоны зам” олон улсын авто-реали тэмцээний зохион байгуулалтын ажилд оролцох комисст Ж.Амаржаргал, Б.Бэрхгалт нар ажилласан. Улсын архивын үзлэг явуулах удирдамжийн дагуу үзлэгт бэлтгэх төлөвлөгөө гаргаж, цэргийн штабын архив, албан хэрэг хөтлөлт, баримтын хадгалалт хамгаалалтын байдалд үзлэг хийн, дутагдлыг засан ажиллаж байна.

СУМДЫН МЭДЭЭ

БАЯНДАЛАЙ СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гаргасан бодлого шийдвэр

Засаг даргын А захирамж 8, Б захирамж 1, нийт 9 захирамж гаргасан. А захирамж: -Гэрээ байгуулж ажил гүйцэтгүүлэх тухай, цол олгох, ээлжийн амралт, говийн дэмжлэг, газар эзэмших эрхийн дуудлага худалдаа, урамшуулал олгох тухай. Б захирамж: Ажилд томилох. ЗДТГазрын даргын А тушаал 2, нийт 2 тушаал гаргасан А тушаал: -Комисс томилох, Засаг даргын тоот-5, Өргөдөл гомдол-2 Ажилд орох, Хашаажуулах тухай, Ирсэн бичиг-17, хугацаандаа яваа-1, шийдвэрлэж хаасан-2. Шуурхай хурал-3 удаа тус тус хийсэн байна.

Хоёр.Хурал зөвөлгөөн, сургалт, семинар, уулзалт

Төрийн албан хаагчдын хувцаслалтын тухай нэг удаагийн сургалтыг нийт төрийн албан хаагчдад хийсэн.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ

Сургууль, цэцэрлэгүүд амарсан тул мэдээлэл байхгүй. 07 дугаар сарын 01-нд Дэлхийн аварга Ц.Раднаа багшийн нэрэмжит сумын баяр наадмыг зохион байгуулсан. Говийн Оюутан тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж байгаа оюутан залуучууд сумын цэцэрлэгт хүрээлэнд ээжүүд болон болон хүүхэд багачуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх орчинг бий болгож өгсөн. Мөн гүний усны худаг, айлын хашааг будаж өнгө үзэмжийг сайжруулан ажилласан.

Тав. Тухайн сард зохион байгуулсан “Шинэлэг ажил”

Наран багийн 60 жилийн ойн ажлын хүрэннд Наранбагт зүлэг, мод тарих, бүтээн байгууллагын ажлыг хийж жишиг баг болох ажлуудыг хийж байна. Өмнөговь аймаг 2018 оны ажлаараа улсдаа тэргүүлж хошой тэргүүний аймаг болсонтой холбогдуулан төрийн үйлчилгээний 29 албан хаагчдыг шагнаж урамшуулсан. Спорт заалны барилгын ажил суурийн цутгалт 50 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбайн ажил хийгдэж ажил, Соёлын төвийн барилгын ажлууд эхэлсэнтэй холбогдуулан түр ажлын байр бий болж одоогийн байдлаар сумын харьяат 12 хүн ажиллаж байна.

БАЯН-ОВОО СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гаргасан бодлого шийдвэр

Засаг даргын Тамгын газрын даргын А Тушаал 5 гарсан байна. Засаг даргын А Захирамж 13, Б захирамж 1 тус тус гарсан байна.

Хоёр.Хурал зөвөлгөөн, сургалт, семинар, уулзалт

Сумын Засаг даргын Тамгын газрын дарга болон дотоод ажил, хууль эрх зүйн сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтний хамт сургагч багш бэлтгэх сургалтанд амжилттай хамрагдлаа. 2019 оны 6 сарын 26-28-ний өдрүүдэд Гурвантэс суманд зохион байгуулагдсан МАА-н дэвшилтэт арга туршлагын сургалт зөвлөгөөнд ХААИС-ийн эрдэмтэн багш нар, ХАА-н газрын дарга, мэргэжилтнүүд сумын ХАА-н тасаг, МЭ-ийн тасгийн мэргэжилтнүүдийн хамт хамрагдаж, 5 төрлийн зөвлөмж бүхий БАТЛАМЖ гардаж авсан

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ

Сум үүсгэн байгуулагдсаны 95 жилийн ойн баяр наадмаа амжилттай зохион байгууллаа. Татварын орлого бүрдүүлэлт:

-Улсад төсвийн орлого: 16272.4 мян/төг орохоос 32850.9 буюу 201.9 хувь
-Аймагт төсвийн орлого: 116849.6 мян/төг 191310.9 буюу 163.7 хувь
-Орон нутгагт төсөвийн орлого: 59300.9 мян/төг 127961.3 буюу 215.8 хувь татварын орлого тус тус төвлөрүүлсэн байна. Хөдөө аж ахуйн газарт 2 дугаар сарын 15-наас эхлэн төлийн мэдээ, том малын хоргодлын мэдээг долоо хоног бүрийн 3 дахь өдөр мэдээлж байна. Сүүлчийн мэдээгээр төллөвөл зохих 64692 хээлтэгчээс 68,7 хувь буюу 44427 хээлтэгч төллөж, 89 хонь, 228 ямаа, бүгд 317 мал ихэрлэж, 996 ботго, 1365 унага, 276 тугал, 14399 хурга, 27708 ишиг, бүгд 44744 төл гарч эсэн мэнд бойжиж байна. Том малын зүй бус хорогдлоор 14 мал / тэмээ-1 хонь-10, ямаа-3/ хорогдсон байна. Сумын хэмжээнд 7,5 га-д газар тариалан эрхлэж, / 3,2 га-д төмс, 2 га-д хүнсний ногоо, 2 га-д тэжээлийн тэжээлийн ургамал, 0,3 га-д жимс жимсгэнэ/ тариалсан. Төрсний бүртгэлд – 1, гэрлэлтийн бүртгэл - 1, нас барсны бүртгэлд – 3, шилжин ирсэн - 5, Иргэний цахим үнэмлэх олголт 8, гэрлэлт цуцлалт - 0, төрсний гэрчилгээ дахин олголт - 3, үрчлэлтийн бүртгэл - 1, иргэний үнэмлэх захиалга - 4 Үүнд: дахин олголт - 0, шинээр - 2, сунгалт - 2, иргэний үнэмлэх олголт - 8, бүх төрлийн лавлагаа авах – 4 иргэний өргөдөлийг ОӨУБХэлтэст хүргүүлсэн. Иргэний бүртгэлийн чиглэлээр 42 бүртгэл хийгдсэн байна. Үл хөдлөх хөрөнгийн анхны бүртгэлийн мэдүүлэг – үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ олголт 2 хийгдсэн. 4 иргэн, 1 хуулийн этгээдэд хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр эрх зүйн зөвлөгөө үзүүлсэн.

БУЛГАН СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр

Сум бүрт жишиг хоршоог хөгжүүлж түүхий эдийн анхан шатны боловсруулалтын цэг байгуулах төслийг зарлаж олон нийтэд ил тод байдлаар явуулла. Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих жижиг, дунд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөөр хангах төслийг зарлаж олон нийтэд ил тод байдлаар явууллаа.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт .

Говийн бүсийн аймгуудын сумын Засаг даргын Тамгын газрын дарга нарын “Цэргийн бэлтгэл” сургалтанд хамрагдсан

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ

Төсөвт байгууллагуудын 7-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр авлагын мэдээг нэгтгэн Төрийн сангийн программд шивж мэдээлэв. 7-р сарын Орон нутгийн орлогыг хаалтын дансруу хааж, гүйцэтгэлийг татварын байцаагчтай тулган аймагт мэдээлэв. Аймагас ирсэн 2019 оны 8-р сарын санхүүгийн дэмжлэгийг орлогын дансанд хааж, орон нутгийн байгууллагын санхүүжилтийг олгов. Төсөвт байгууллагуудын 8-р сарын гүйлгээг хийж байна. Газар тариалан 26,4 га талбайд хүнсний ногоо тариалж эрт ургацын өргөст хэмх 2,3тн, улаан лооль 3тн хураан авч борлуулж байна. МАА-д байгаль цаг уурын нөхцөл байдал сайн байгаа тул алсын отор нүүдэлгүй сааль, сүү арвин байна. Эмнэлэгийн дотоод хурал 6, нийт үйлчлүүлэгчийн тоо 68, жирэмсэн эх 25, вакцинжуулалт 10, түргэн тусламжын дуудлага 17 ирсэн байна.

МАНДАЛ-ОВОО СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.

Сумын Засаг даргын захирамж 11, Засаг даргын Тамгын газрын даргын тушаал 2.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт

Засаг даргын Тамгын газрын дотоодын шуурхай хурал 3, албан байгууллагын дарга эрхлэгчдийн хурал цуглааныг 1 удаа зохион байгуулж, цаг үеийн тулгамдсан асуудлаар ярилцаж шийдвэрлэв.

Үүнд:

Засаг даргын Тамгын газрын дотоодын шуурхай хурал 2 удаа зохион байгуулж, цаг үеийн тулгамдсан асуудлаар мэдээлэл солилцож, ярилцаж шийдвэрлэсэн байна.

Үүнд:

- Өргөдөл хүсэлтийг бүртгэж, шийдвэрлэх тухай
- Нутгийн удирдлагын ордны гэрээ байгуулах тухай
- Түүхий эд боловсруулах цэгийн гэрээ байгуулах эрх олгох тухай
- Эсгийний үйлдвэрийн тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээ байгуулах тухай
- Орон нутагт дутагдалтай хүний нөөцийг бүрдүүлэх тэтгэлэгт хөтөлбөрийн мэдээлэл түгээх тухай
- ОНХС-н хөрөнгөөр хэрэгжүүлэх Гэрэлтүүлэг шинээр хийх, гэрэлтүүлгийн засварын ажлын гэрээ байгуулах тухай
- Бог малын хээлтүүлэгчийг ялган суурилуулах суурийн хашаа, худаг засварлах ажлын гэрээ байгуулах тухай
- Тамгын дарга Баянхонгор аймагт Цэргийн сургалтад хамрагдах тухай
- Цэвэр бохир усны шугамын ажилд хяналт хийх тухай
- Говийн оюу ХДС-н квотийн хөрөнгөөр санхүүжигдэх Аюулгүй орчин-хүүхдийн ирээдүй төслийн гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай
- Говийн оюу ХДС-н квотийн хөрөнгөөр санхүүжигдэх Ясли-хүүхдийн хөгжил төслийн гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах тухай
- Мандал Баянхошуу багийн өвөлжөө хаваржааны цэгийг тогтоох тухай

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлт, тухайн сард зохион байгуулсан ажил, арга хэмжээ

Нутгийн удирдлагын ордны барилга угсралтын гэрээг Зана констракшн ХХК-тай байгуулав. Түүхий эд боловсруулах цэгийн гэрээг Батжин ойл ХХК-тай байгуулав. Эсгийний үйлдвэрийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гэрээг иргэн Ө.Эрдэнэтуяатиа байгуулж, хүлээн авав. Орон нутагт дутагдалтай хүний нөөцийг бүрдүүлэх тэтгэлэгт хөтөлбөрийн мэдээлэлийг цахим болон мэдээллийн самбар, багийн дарга нараар дамжуулан иргэдэд хүргэж ажиллав. ОНХС-н хөрөнгөөр хэрэгжүүлэх Гэрэлтүүлэг шинээр хийх, гэрэлтүүлгийн засварын ажлын гэрээг ХААН Мандал ОНӨААТҮГ-тай байгуулав. Бог малын хээлтүүлэгчийг ялган суурилуулах суурийн хашаа, худаг засварлах ажлын гэрээг иргэн Ц.Алтангэрэлтэй байгуулж, гүйцэтгэлийг хүлээн авав. Тамгын дарга 8 сарын 1-3 нд Баянхонгор аймагт говийн бүсийн Цэргийн сургалтад хамрагдав. Цэвэр бохир усны шугамын ажилд ХШҮ хийв. Гүйцэтгэл 40 хувьтай байв. Говийн оюу ХДС-н квотийн хөрөнгөөр санхүүжигдэх Аюулгүй орчин-хүүхдийн ирээдүй төслийн гүйцэтгэгч Хайрхан баян бор ХХК-д гэрээ байгуулах эрх олгов. Говийн оюу ХДС-н квотийн хөрөнгөөр санхүүжигдэх Ясли-хүүхдийн хөгжил төслийн гүйцэтгэгч Мандал стиль ХХК-тай гэрээ байгуулав.

Дөрөв. Багт зохион байгуулагдсан ажлууд

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдсэн Багийн дэмжлэг хөтөлбөрийн 30 сая төгрөгний хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг хүлээн авав. Баянхошуу багт өвөлжөө бууцны цэг тогтоох ажил хийгдэв

НОЁН СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.

Засаг Даргын “Заан цол олгох” тухай, “Говийн дэмжлэг олгох” тухай нийт 2 захирамж гаргасан байна.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ

2019 оны бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж байна. Сум дундын эмнэлэгийн шинэ барилгын гүйцэтгэл 70 хувьтай явагдаж байна. Гүйцэтгэгч компани Шинэ Их холдолт ХХК, Сумын төвд цэвэр ус, бохирын шугам тавих ажлыг Б-софт ХХК гүйцэтгэж, гүйцэтгэл 80 хувьтай хэвийн явагдаж байна. "Орон нутгийн хамтын ажиллагаа"-ны зөвлөлөөс сумын төвийн хойд байрны тогны хүчин чадлыг сайжруулах дэд станц барих 20 сая төгрөгний төсөл зарлагдсан. Төслийг Ноён сумын иргэн Д.Өнөрбаяр авч ажлыг гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. ОНХС-н хөрөнгө оруулалтаар ЗДТГ-ын талбайн тохижилтийн ажлыг Төгс үлэмжийн чанар ХХК гүйцэтгэж гүйцэтгэл 40 хувьтай явагдаж байна. Ноён сум үүсч хөгжсөний түүхт 96 жил, Ерөнхий боловсролын сургууль үүсгэн байгуулагдсаны түүхт 80 жилийн ойг 07 дугаар сарын 01,02-ны өдөр зохион байгуулагдлаа. Ноён бондоолой хүүхдийн сувилал 4 дэх жилдээ зохион байгуулагдаж 07 дугаар сарын 07-18 хүртэл зохион байгуулагдаж 0-2 насны нийт 15 хүүхэд

хамрагдлаа. ЕБС-ийн түүхт 80 жилийн ойн хүндэтгэлийн концерт, Ноён сум үүсч хөгжсөний 96 жилийн ойн баяр наадмын урлагийн тоглолтын арга хэмжээг зохион байгууллаа.

Дөрөв. Тухайн сард зохион байгуулсан шинэлэг ажил

Хөдөлмөр зуучлалын программд ажил идэвхитэй хайж байгаа 14 иргэн байна. Ажил хайгчын бүртгэл шинээр 5 иргэн бүртгүүлсэн. 5 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан. Шинээр 16 түр ажлын байр бий болсон. Төсөвт байгууллагууд болон хувийн хэвшлийн байгууллага, уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг компани дээр үйлдвэрлэлийн болон ахуйн осол аваар, хурц хордлого гараагүй. Төсөвт байгууллагууд болон хувийн хэвшлийн байгууллага, уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг компани дээр үйлдвэрлэлийн болон ахуйн осол аваар, хурц хордлого гараагүй. Шүдний хөнгөлөлтийн материал-2 группын сунгалт-2, ажилд орох анкет 14, байнгын асаргааны тэтгэмж-31, группын тэтгэвэр-16, тэжээгчээ алдсаны тэтгэвэр-4, хүүхэдасарсны тэтгэмж- 64, ажилгүйдлийн бүртгэлд хамрагдах 3 иргэний анкет, төсөл хөтөлбөрт хамрагдах хүсэлт-2 Нийт 136 иргэний өргөдөл материал, хувийн хэрэгт үндэслэн шийдвэрлэлээ.

НОМГОН СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.

Сумын Засаг даргын “А” захирамж 10 гарсан байна. Б захирамж гараагүй. Засаг даргын Тамгын газрын даргын “А” тушаал 5, Б тушаал гараагүй.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт,

Сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын болон албан байгууллагуудын дарга, эрхлэгч нарын “Шуурхай хурал” 2 удаа хуралдаж, удирдлагуудаас цаг үеийн мэдээлэл өгч, үйл ажиллагаатай нь танилцаж, санал солилцлоо.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ

Эрүүл мэндийн төвийг цэвэр бохирт холбох ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог байгуулж, ажиллаж байна. Эрүүл мэндийн төвийг цэвэр бохирт холбох ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог байгуулж, ажиллаж байна. Сумын төвийн өрхүүдийн газрын кадастр хийгдэж байна. Нийт шинээр төрсөн 22 хүүхэд, овог, нэр өөрчлөлт 1, гэрлэлт 1, нас баралт 3, ирсэн 13 тус тус бүртгэгдсэн байна. Гэр бүлийн асуудлын талаар 6 иргэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн байна. Иргэдэд цаг тутамд Нийгмийн даатгалын шинэлэгдсэн хууль, дүрэм, журам, малчин даатгуулагчийн өндөр насны тэтгэврийн хуулийн мэдээллийг өгч ажиллаж байна. Хүүхдийн зуны сувилалыг нээн ажиллуулж байна.

Дөрөв. Тухайн сард зохион байгуулсан шинэлэг ажил

Хүүхдийн зуны сувилалыг нээн ажиллуулж, Баян булаг газар тариалангийн 8 га газрыг сумын ОНХСангаар хашуулах ажил хийгдэж байна. 2019 оныг “Хөдөө аж ахуйн үйлдвэржилтийн жил” болгосонтой холбогдуудан иргэдэд сурталчлах самбар, гарын авлага хийж иргэдэд мэдээлэл хүргэж ажиллаж байна. Суманд малын арьс шир, түүхий эдийн анхан шатны боловсруулалт хийх цэг байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог байгууллаа.

Тав. Багт хийгдсэн ажлууд

Багууд 60 жилийн оыг тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлыг хийж байна аймгийн санхүүжилтаар Богт багийн Үзүүр цов, Дэрсэнэ ус багийн Холбоо толгой ын гүн өрмүүдийн худгийн байшин, тоног төхөөрөмжийг суурилуулсан. Багийн Засаг дарга, эмч нар багийнхаа малчин өрхөөр баг тус бүртээ явж, зуншилтийн байдалтай танилцаж, иргэдийнхээ санал бодлыг сонсож, улс, аймаг, сумын цаг үеийн мэдээллийг хүргэж ажиллаж байна. Зуншлага гандуу байгаагаас Эмгэн булаг, Богт багийн малчин өрхүүд сумаас хойш оторт байна.

СЭВРЭЙ СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.

Сумын Засаг даргын 12 захирамж боловсруулагдан гарсан. /Ажлын хэсэг байгуулах тухай-1, хөрөнгө зарцуулах тухай-1, гэрээ байгуулж ажил гүйцэтгүүлэх тухай-3, Шагнал урамшил олгох тухай-2, ажил хүлээн авах тухай-2, Ээлжийн амралт олгох тухай-2, Үр дүн олгох тухай-1/

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт,

Засаг даргын Тамгын газрын дарга Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас Баянхонгор аймагт зохион байгуулагдсан Говийн бүсийн аймгуудын сумдын Тамгын газрын дарга нарын цэргийн бэлтгэл сургалтанд 3 хоногийн турш хамрагдсан. 8 сарын 15-наас 19 ний өдрүүдэд Өмнөговь аймгийн төвд зохион байгуулагдсан багш нарын сургалт семинарт судлагдахуун тус бүрээр бага ангийн 6 багш төрөл мэргэжлийн 9 багш.сургуулийн нийгмийн ажилтан сургалтын менежер захирал нийт 19 хүн хамрагдсан.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ

Сум 95 жилийн ажлын амжилтаа үнэлүүлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 07 сарын 17-ны өдрийн зарлигаар төрийн дээд шагнал “Алтан гадас” одон хүртэж, одон хүлээн авах мялаалга наадмыг 7 дугаар сарын 29-ны өдөр сумын төвд зохион байгуулсан. Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Хонгорын хурд” наадам 8 дугаар сарын 15-ны өдөр Хонгорын гол Цагаан толгойд зохион байгуулагдаж Хүчит бөх барилдан 3 насны морь уралдаж, Үндэсний сурын харваа зохион байгуулагдлаа. 8 дугаар сарын 19-ны өдрөөс эхлэн Сайншанд Бүйлсэн багийн 25 ахмадыг “Нүдэн булаг” ахмадын амралт сувилалын төвд амруулж эхэлсэн нийт 14 хоног эмчилгээ сувилгаа хийнэ. Орон нутгийн төсвийн 300 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар сумын төвийн дулаан цэвэр усны шугамын өргөтгөлийн ажил эхэлж байна. Нийт 550м цэвэр ус болон дулааны шугам тавигдаж шинэ сууршилын бүс болон дулаанд холбогдоогүй төрийн болон хувийн өмчийн обектууд холбогдоно. Уг ажлыг Өмнөговь аймгийн "ГОВЬ ДУЛААН" ххк гүйцэтгэж эхэллээ.

Дөрөв: Тухайн сард зохион байгуулсан шинэлэг ажил

Долоо хоног бүрийн Пүрэв гаригийг ахмад настан болон ард иргэд залуучуудад зориулсан бүжгийн өдөр болгосон байна. Өдөр бүр 10-12 цагын хооронд ахмадууд спорт заланд тогтмол бэлтгэл хийж хэвшиж байна.

ХАНБОГД СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр

Ирсэн бичиг-25, Хугацаа хэтэрсэн-0, Шийдвэрлэсэн-5, Өргөдөл, гомдол-0, Засаг даргын захирамж- А-1, Б-0, Засаг даргын тоот-5, Засаг даргын Тамгын газрын даргын тушаал- А-0, Б-0, Засаг даргын Тамгын газрын даргын Шуурхай хурал-1, ИТХ-ын тогтоол -0 тус гаргасан байна.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ

Сумын гудамж талбайн өнгө үзэмжийг сайжруулах гэрэлтүүлэг чимэглэлийг сайжруулж ӨМӨЗО-ны Баяннуур аймагтай хамтран ажиллах хүрээнд сумын гэрэлт хаалга гэрэлт гудамжийг барьж ашиглалтанд орууллаа. Өмнөговь аймгийн Засаг даргын ивээл дор Өмнөговь аймгийн ЗДТГ, БСУГ, Ханбогд сумын ИТХ, ЗДТГ, БНСУ-ын Роботын нийгэмлэг, Монголын роботын боловсролын нийгэмлэг, төрийн өмчит ОУ-ын сургуулиуд, Өмнөговь аймгийн ЕБС-иуд хамтран, Оюу толгой ХХК, Говийн Оюу хөгжлийн сангийн дэмжлэгтэйгээр ЛЕГО РОБОТЫН БҮСИЙН СУРГАЛТ-ТЭМЦЭЭН-ийг Ханбогд суманд зохион байгууллаа.